



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/227

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Хогийн төвлөрсөн цэгийг хашаажуулах (Рашаант сум)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Дансран дүвчин” ХХК-тай 69,920,086 (жаран есөн сая есөн зуун хорин мянга наян зургаа) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т, тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Дансран дүвчин” ХХК-ийн захирал (М.Бадамсүрэн)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010296

2026 өдөр бүр Doc2026/31/31

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 31-ны/ний өдрийн
A/227 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Очирсүрэн
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Очирсүрэн А.Гантөмөр
3	Ажил хугацаа гүйцэтгэх	Хуанлийн 45 хоног	А.Гантөмөр

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 31-ний өдрийн
А/227 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Д.Нандинцэцэг	А.Гантөмөр
2	ХАБЭА-н ажилтан	М.Бадамсүрэн	
3	Гагнуурчин	Ч.Цолмонбаатар	
Машин механизмын жагсаалт			А.Гантөмөр
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Ачааны автомашин	7369УКН	

--o00o--